



Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

2018 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Засаг даргын А/29 тоот захирамжаар Эх үрсийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэх, зохион байгуулах ажлын хэсгийг байгуулав. Дараах ажлуудыг зохион байгууллаа.



Нийгмийн бодлогын хүрээнд:



Эх үрсийн баярын өдөр сумын Засаг даргаар батлуулсан хөтөлбөрийн дагуу 3 насны ангилалд хүүхэд багачуудын дунд дугуйн уралдаан, “Миний ээж хөөрхөн” гар зургийн уралдаан, Аав, ээж би тэмцээнийг зохион байгууллаа.

Мөн 8-аас дээш хүүхэд төрүүлэн өсгөсөн ээжүүдийг алдаршуулах “Манлай ээж -2018” өргөмжлөн хүндэтгэл үзүүлэв. Мөн шинээр одон авсан 3 ээжүүдэд хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



Нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас зохион байгуулсан ажил:



ЗДТГазар сумын ААНБ-ууд болох Мөнх хүлэг хурд ХХК, Цэдэн хан ХХК, Ганболд металл ХХК, Сайжирна дэлгүүр, Арвижих дэлгүүр, үсчин, Хаан банк, Цагдаагийн хэсэг, Хөгжих лүн тал ХХК, Цэргийн анги зэрэг байгууллагуудтай хамтран Нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд багачуудад баярын бэлэг түгээн, шинээр одон авсан 3 ээжүүдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.

Мөн 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдөр сумын эмэгтэйчүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж нийт 12 баг оролцлоо.



1-р багийн мэдээлэл



2018 оныг хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан 1-р багаас санаачлан идэвхи санаачлагатай иргэдээ алдаршуулан Хариуцлагатай багш, хөдөлмөрч иргэн, санаачлагатай иргэн 8 иргэнийг өргөмжлөн урамшууллаа. Уг үйл ажиллагааг Говийн сондор ХХК, 1-р багийн малчин Б.Тойруул нар ивээн тэтгэн хамтран ажиллалаа.



2-Р БАГИЙН МЭДЭЭЛЭЛ

2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 2-р багийн Багийн Иргэдийн нийтийн хурал боллоо. БИНХ-аар 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлын тайлан, 2019 онд хэрэгжүүлэх ажлуудыг хурлаар хэлэлцэн эрэмбэллээ.



Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:



“Бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх” нийтийг хамарсан ажилд оролцох, сумын харьяат, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны иргэдийг 18 иргэнийг ажиллуулж байна. Мөн Мэргэжлийн хяналтын газраас заралсан эрүүл мал эрсдэлгүй бүтээгдэхүүн сарын аяны хүрээнд сургалт зохион байгуулж 23 малчин өрх хамрагдсан



Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:



Сумын хэмжээнд нийт 30027 хээлтэгч төллөхөөс 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 26235 хээлтэгч төллөж, 25519 төл бойжиж, мал төллөлт 97 хувьтай, зүй бусаар хорогдсон 1941 мал, нийт малын 3 %-ийг эзлэж байна.



Хөдөлмөр халамжийн хүрээнд:

Мөнхтал дэлгүүрээс 7 өрхийн 38 иргэн 5 р сарын хүнсний бараагаа хүнсний эрхийн бичгээр худалдан авсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд ахмад настны "Малын хишиг" бүлгийн төсөл дэмжигдэж, 500,000 мянган төгрөгний санхүүгийн дэмжлэг олгох гэрээ байгуулсан байна.

Эх үрсийн баяраар сумын ААНБайгууллагаас зохион байгуулсан "Хүүхэд бүхэн бэлэгтэй" үйл ажиллагаанд хөгжих өрх, хүнсний эрхийн бичигт хамрагддаг 10 өрхийн хүүхдүүд оролцож баярын бэлэгээ авлаа.



Хөдөлмөр, халамжийн хүрээнд:



Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Бэлчээрийн мэрэгч амьтантай тэмцэх” нийтийг хамарсан ажил 2018 оны 05 р сарын 23 нд эхлэн явагдаж байна. Хөдөлмөр эрхлээгүй 18 иргэн хамрагдсанаас хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн, хүнсний эрхийн бичиг, хөгжих өрхийн нийт 3 өрхийн 4 хүн хамрагдсан байна.

Нийтийг хамарсан ажлын явцад сумын Засаг дарга Д.Мөнх-эрдэнэ, ЗДТГазрын Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга Б.Мөнгөнцэцэг, ХХҮ ний мэргэжилтэн Г.Болормаа нар хяналт тавьж, ажлын заавар зөвөлгөө өгсөн байна. Ажиллагсадыг МЭҮТасаг болон 2 р багийн Засаг дарга Б.Энхтөр нар хуваарийн дагуу хариуцан ажиллаж байна.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Бүлгээр ногоо тарих төсөлд 4 иргэн хамрагдсанаас хөгжих өрхийн болон хүнсний эрхийн бичигт хамрагдаж байгаа 2 өрхийн 3 хүн, өрх толгойлсон 1 эмэгтэй хамрагдаж байна. Бүлгийн гишүүд хүнсний ногоо тариалах сургалтад хамрагдаж, газраа хагалан бэлтгэж, усалгаагаа хийсэн байна.

Өрхийн аж ахуй эрхэлж байгаа 2 ахмад настны Эсгий ширмэл бүтээгдэхүүн, Сүүн далай зэрэг төслүүд, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэний “Оготно устгах төхөөрөмж хийх” төсөл нь эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдаж, төсөл хэрэгжүүлэх гэрээгээ байгуулсан.



Байгаль орчны хүрээнд:



Талын-Илч ОНӨҮГазар спорт заалны шатсан туурийг цэвэрлэж нийт 200 тонн хог хаягдлыг хогийн цэгт хаясан.